



Монгол Улсын Их Хурлаас батлагдаж, 2023 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөх татварын хууль тогтоомжийн зарим голлох нэмэлт, өөрчлөлтүүдийн талаар бид энэхүү татвар болон хууль эрх зүйн мэдээллээрээ та бүхэнд танилцуулж байна.

Татварын эрх зүйн орчинд хийгдсэн эдгээр өөрчлөлт, шинэчлэлтүүдийн зорилго, гол нөлөөллийг дараах байдлаар нэгтгэн дүгнэж болохоор байна:

- Улаанбаатар хотоос гадна үйлдвэр, агуулахаа нүүлгэх эсхүл хөдөө орон нутагт шинээр хөрөнгө бий болгох, хөдөө орон нутагт шинээр ажилтнууд ажиллуулах зэрэг үйл ажиллагааг татварын бодлогоор дэмжих;
- Хөрөнгө оруулалтын сан, инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үйлдвэрлэдэг гарааны компани, дулаан, цахилгаан үйлдвэрлэх төсөл болон гадаад, дотоодын хөрөнгийн биржид хувьцаагаа нээлттэй арилжаалах үйл ажиллагааг татварын бодлогоор дэмжих;
- Хөдөлмөр эрхлэлтийн орлогод шаталсан хувь хэмжээгээр орлогын албан татвар ногдуулах;
- Татварын албаны мэдээлэл солилцоо, татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн баазыг өргөтгөх; болон
- Татварын зорилгоор хөрөнгийн үнэлгээ хийх эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд

Хамаарах хэсэг	Гол нэмэлт, өөрчлөлтүүд	Тавигдах нөхцөлүүд
а) Хасагдах зардал	Татвар төлөгч нийслэл хотод байрлалтай үйлдвэр, эсхүл агуулахаа Багануур, Багахангай, Налайх дүүргээс бусад нийслэлийн хилийн цэсээс нүүлгэсэн тохиолдолд тухайн нүүлгэн шилжүүлэхтэй холбогдон гарсан зардлыг 50 хувиар нэмэгдүүлж тооцох;	1) Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг татвар төлөгчид хамаарахгүй; 2) Хасагдах зардлын ерөнхий шаардлагуудыг хангасан байх.
	Багануур, Багахангай, Налайх дүүргээс бусад нийслэл хотын хилийн цэсээс гадна үндсэн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг, хуулийн этгээдийн ерөнхий захиргаа нь үйл ажиллагааг явуулж байгаа тухайн орон нутагт бүртгэлтэй, тухайн орон нутгийн татварын албанд бүртгэгдсэн албан татвар төлөгч ажил хайгч иргэнийг хөдөлмөрийн гэрээний дагуу үргэлжилсэн 12 сарын хугацаанд нийт 183 ба түүнээс дээш хоног шинээр ажиллуулсан бол тухайн хугацаанд хамаарах цалингийн зардлыг 20 хувиар нэмэгдүүлж, нэг удаа хасаж тооцох;	
	Албан татвар төлөгч гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч зах зээлд нийтэд санал болгон нээлттэй арилжаалагдах үнэт цаас гаргасан тохиолдолд үнэт цаас гаргах үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан зардлыг 20 хувиар нэмэгдүүлж тооцох;	1) Хасагдах зардлын ерөнхий шаардлагуудыг хангасан байх.
	Нийтийн тээврээр нийслэл хот дотор зорчих тасалбар, эсхүл зорчих эрхийг бэлэн мөнгөнөөс бусад хэлбэрээр ажилтандаа олгосон Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн тухайн тасалбар, зорчих эрх худалдан авсантай холбогдох зардлыг 50 хувиар нэмэгдүүлж тооцох.	

Татварын хууль тогтоомжид орсон өөрчлөлтүүдийн талаар дэлгэрүүлэн хэлэлцэх, эсхүл танай бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд татварын мэргэшсэн зөвлөхүүдийн тусалцаа хэрэгтэй бол бидэнтэй холбогдоно уу.

Холбоо барих:

Майкл Ахэрн

Партнер
Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Жамбалын Энхзул

Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhzul.jambal@pwc.com

Эрдэнэ-Очирын Энхсанаа

Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhkanaa.erdene-ochr@pwc.com

ПрайсвотэрхаусКүүперс

Такс ТМЗ ХХК
Сентрал Тауэр, 6 давхар
601тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : + 976 11 322068
www.pwc.com/mn

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд (үргэлжлэл)

Хамаарах хэсэг	Гол нэмэлт, өөрчлөлтүүд	Тавигдах нөхцөлүүд
б) Элэгдэл	Нийслэл хотын Багануур, Багахангай, Налайх дүүрэг болон бусад аймаг, суманд шинээр бий болгосон албан татвар төлөгчийн 1 ба түүнээс дээш жилийн хугацаанд ашиглах хөрөнгөд өөрийн сонголтоор 15 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдэл тооцож болно.	1) Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг татвар төлөгчид хамаарахгүй; 2) Элэгдэл тооцож эхлэхээс өмнө харьяалах татварын албанд мэдэгдсэн байна.
в) Татварын хөнгөлөлт	2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх дулаан, цахилгаан үйлдвэрлэх төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 3 жил 90 хувь, дараагийн 3 жил 50 хувиар хөнгөлөх.	Тухайн төсөлд хамаарах орлого, хасагдах зардал, алдагдал, хөнгөлөлт, чөлөөлөлт зэрэг татварын тооцоог хийж, тухайн төслийн татварын тайланг тусдаа гаргаж тайлагнана.
	Улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш 5 жилийн хугацаанд дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацын бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг хөнгөлөх.	Инновацийн тухай хуульд заасан гарааны компанид хамаарна.
г) Чөлөөлөх орлого	Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлого.	
д) Татварын хувь хэмжээ	Программ хангамж боловсруулах, хөгжүүлэх үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг татвар төлөгч өөрийн үндсэн үйл ажиллагаанд ашиглах программ хангамжийн эрхийн шимтгэл, сервер түрээслэх төлбөртэй холбоотойгоор шилжүүлсэн орлогод 5 хувиар татвар ногдуулах.	1) Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг татвар төлөгчид хамаарахгүй; 2) Хэрэглэгч нь Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, үйлчилгээ үзүүлэгч нь Монгол Улсад байрладаггүй этгээд байх.
	Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалах хувьцааг худалдан авсан албан татвар төлөгчийн ногдол ашгийн орлогод 5 хувиар татвар ногдуулах.	Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг татвар төлөгчид хамаарахгүй.

Татварын хууль тогтоомжид орсон өөрчлөлтүүдийн талаар дэлгэрүүлэн хэлэлцэх, эсхүл танай бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд татварын мэргэшсэн зөвлөхүүдийн туслалцаа хэрэгтэй бол бидэнтэй холбогдоно уу.

2. Хувь Хүний Орлогын Албан Татвар (ХХОАТ)-ын хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу 2023 оноос эхлэн хөдөлмөр эрхлэлтийн татвар ногдуулах орлогын дүнд дараах хувь хэмжээгээр татвар ногдуулна:

Жилийн орлого (₮)	Татварын хэмжээ (%)
0 - 120 сая (сарын 0-10 сая)	10%
120 сая - 180 сая (сарын 10-15 сая)	12 сая төгрөг дээр нэмэх нь 120 сая төгрөгөөс дээш давсан орлогод 15%
180 сая төгрөгөөс дээш (сарын 15 сая төгрөгөөс дээш)	21 сая төгрөг дээр нэмэх нь 180 сая төгрөгөөс дээш давсан орлогод 20%

Илүү дэлгэрэнгүйг манай 2022 оны 12-р сард гаргасан Татвар болон хууль эрх зүйн мэдээлэл [Дугаар 11/2022](#)-аас үзнэ үү.

3. Татварын Ерөнхий Хууль (ТЕХ)-д орсон нэмэлтийн дагуу цахим төлбөрийн баримтыг нийлүүлэлтийн үе шат бүрээр бүртгэнэ

Бараа, бүтээгдэхүүн, ашигт малтмалыг үйлдвэрлэл, борлуулалт, импорт, экспортын үе шат бүрээр цахим төлбөрийн баримт, гаалийн мэдүүлэг, гаалийн лабораторийн дүгнэлтэд үндэслэн татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх ба бүртгэхтэй холбоотой журмыг Сангийн Яам гаргана.

4. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар (ҮХЭХАТ)-ын тухай хуульд орсон 2022 оноос хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлтүүд

а) Чөлөөлөх орлого

- Нийслэл хотын тусгай бүсэд бүртгэгдсэн барилга байгууламж;
- Иргэн, хуулийн этгээдийн өмчилж байгаа аймаг, суман дахь орон сууц, нийслэл дэх хоёр орон сууц. Үүнээс бүх орон сууцыг ҮХЭХАТ-аас чөлөөлдөг байсан;
- Үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэр дэх үл хөдлөх эд хөрөнгийг ҮХЭХАТ-аас эхний 5 жилд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлөх. Энэ нэмэлт 2022 оны 8-р сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр болсон.

б) Татварын хувь хэмжээ

- ҮХЭХАТ-ын хувь хэмжээ 0.6%-1.0% байсныг 0.6%-2.0% болж нэмэгдүүлсэн. Энэ хязгаарт багтаан аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан ҮХЭХАТ-ын хувь хэмжээг тогтоодог.

5. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга

Уг хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас 2022 оны 6-р сарын 17-ний өдөр баталсан ба 2023 оны 1-р сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Уг хуулиар татварын зорилгоор хөрөнгийн үнэлгээ хийх зохицуулалтыг нэвтрүүлсэн ба холбогдох журам, загварын аргачлалыг Сангийн яамнаас гаргана.

6. Ашигт малтмалын тухай хуульд орсон, 2023 оноос мөрдөх нэмэлт, өөрчлөлтүүд

а) Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

- Хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нэгэн адил төлж, тайлагнана. Хайгуулын ажлын технологийн явцад туршилтын журмаар олборлох ашигт малтмалын дээд хязгаарыг төрлөөс нь хамааруулж Засгийн газар журмаар зохицуулна.

б) Тусгай зөвшөөрлийг цуцлах

- Төрийн захиргааны байгууллага хайгуулын, ашиглалтын болон үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийг цуцалсан бол татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж өдөр тутмын сонинд нийтэлнэ.

в) Татварын албанд мэдээлэл хүргүүлэх

- Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шинээр хүргүүлэх мэдээлэл:
 - ашиглалтын тусгай зөвшөөрөл болон үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгосноос хойш ажлын 7 өдөрт багтаан;
 - хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон даруйд;
 - хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгамагц
- Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шинээр хүргүүлэх мэдээлэл:
 - хайгуулын ажлын төлөвлөгөөг хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш 30 хоногийн, дараагийн жилүүдэд тухайн оны төлөвлөгөөг 04 дүгээр сарын 15-ны дотор;
 - хайгуулын ажлын жилийн тайланг төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;
 - аюулгүй ажиллагааны талаархи мэдээг жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор.